

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

343.	Элчин сайдыг тохоон томилох тухай	Дугаар 112	1289
344.	Элчин сайдыг тохоон томилох тухай	Дугаар 113	1289

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

345.	Хөтөлбөр баглах тухай	Дугаар 215	1290
346.	Хөрөнгө гаргах тухай	Дугаар 225	1299

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2014 оны 08 дугаар
сарын 11-ний өдөр

Дугаар 112

Улаанбаатар
хот

Элчин сайдыг тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Гүрж Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Жагирын Сүхээг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2014 оны 08 дугаар
сарын 11-ний өдөр

Дугаар 113

Улаанбаатар
хот

Элчин сайдыг тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр



зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Армян Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Шүхэрийн Алтангэрэлийг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2014 оны 7 дугаар
сарын 4-ний өдөр

Дугаар 215

Улаанбаатар
хот

Хөтөлбөр батлах тухай

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 6, 7, 8 дугаар зүйлийг үндэслэн, Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Үндэсний соёлын өвийг бүртгэн баримтжуулах 2 дахь шатны хөтөлбөр”-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хэрэгжилтийн явцад хяналт тавьж ажиллахыг Соёл, спорт, аялал жуулчлалын сайд Ц.Оюунгэрэлд даалгасугай.

3. “Үндэсний соёлын өвийг бүртгэн баримтжуулах 2 дахь шатны хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга, Хил хамгаалах ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт тус тус үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.АЛТАНХУЯГ

**СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН САЙД**

Ц.ОЮУНГЭРЭЛ

Засгийн газрын 2014 оны 215 дугаар
тогтоолын хавсралт

ҮНДЭСНИЙ СОЁЛЫН ӨВИЙГ БҮРТГЭН БАРИМТЖУУЛАХ 2 ДАХЬ ШАТНЫ ХӨТӨЛБӨР

Нэг. Хөтөлбөрийн эрх зүйн үндэслэл

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын стратегийн зорилтод “Монголчуудын уламжлалт соёлын биет болон биет бус өвийг хадгалах, хамгаалах, сэргээх, үндэсний хийгээд дэлхий дахины танин мэдэхүй, боловсролын нийтлэг хүртээл болгон дэлгэрүүлэн хөгжүүлэх үйл ажиллагааг дэмжих...”, Төрөөс соёлын талаар баримтлах бодлогын 4.2.11 дэх заалтад “Төрийн болон төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагын оролцоог хангасан соёлын мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгож, иргэдэд соёлын үнэт зүйлийн тухай мэдээлэл олж авах, хүртэх боломжийг нэмэгдүүлэх”, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 6.1 дэх хэсэгт соёлын өвийн тогтолцоог байгууллага дахь бүртгэл, мэдээллийн сан, сум, аймаг, нийслэлийн бүртгэл, мэдээллийн сан, улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан байхаар, 7.2 дахь хэсэгт “бүртгэл, мэдээллийн сан нь тухайн түүх, соёлын дурсгалт зүйлийн зэрэглэлийг тодорхойлох, хадгалж хамгаалах, өвлүүлэх, түүнчлэн түүх, соёлын дурсгалт зүйл эвдэрч гэмтсэн, соёлын биет бус өв нь устсан, мартагдсан тохиолдолд тэдгээрийг сэргээхэд шаардагдах бүрэн мэдээллийг агуулсан байвал зохино” гэж заажээ.

Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Соёлын өвийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн тогтолцоог шинэ шатанд гаргаж, улсын нэгдсэн бүртгэлийн цахим мэдээллийг хил, гааль, цагдаа, мэргэжлийн хяналтын дотоод сүлжээтэй холбох” гэж тус тус заасан нь соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн үйл ажиллагааг цахимжуулж, мэдээллийн урсгалыг шуурхай хүлээн авах, дамжуулах, цахим мэдээллийн аюулгүй байдлыг хангах талаар хөтөлбөр хэрэгжүүлэх эрх зүйн үндэслэл болж байна.

Хоёр. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндэслэл

Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 244 дүгээр тогтоолоор Үндэсний соёлын өвийн бүрэн мэдээллийг бүрдүүлэх, соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн тогтолцоог сайжруулах,



соёлын өвийн мэдээллийг тоон системд оруулан, нэгдсэн сүлжээ бий болгох, мэдээллийг шуурхай дамжуулах, найдвартай хадгалах нөхцөлийг бүрдүүлэх зорилго бүхий “Үндэсний соёлын өвийн мэдээллийг тоон системд оруулан хадгалах хөтөлбөр”-ийг баталж 2006-2008 онд хэрэгжүүлсэн билээ.

Уг хөтөлбөрийг хэрэгжүүлснээр музейн үзмэрийн бүртгэлийн программ хангамжийг боловсруулан улс, орон нутгийн 35 музейд суурилуулж, шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангасан байна. Түүнчлэн бүртгэл, мэдээллийн сангийн орон тоог батлуулж, тэднийг үе шаттайгаар сургалтад хамруулж чадавхижуулах ажлыг зохион байгуулан, музейн нэгдсэн сүлжээ, цахим мэдээллийн сангийн суурийг тавьсан болно.

Хөтөлбөрийн үр дүнд улс, орон нутгийн музей, томоохон сүм хийдэд хадгалагдаж байгаа соёлын өвийн бүртгэл, мэдээллийг Улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хүлээн авах ажлыг шуурхай зохион байгуулахад зохих үр дүнгээ өгч байгаа ч Соёлын өвийг хамгаалах тухай хуульд заасан аймаг, нийслэл, сум, дүүргийн бүртгэл, мэдээллийн санд мэдээлэл хуримтлагдахгүй завсардах, орон нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх болон биет бус соёлын өвийг бүртгэн баримтжуулах, мэдээллийн сан бүрдүүлэх ажил хоцорсоор байна.

Нөгөөтэйгүүр соёлын өв хулгайд алдагдсан, хууль бусаар худалдагдсан тохиолдолд хууль, хяналтын байгууллагыг шуурхай мэдээллээр хангах ажил эхлэл төдий байна. Энэ байдал нь хулгайд алдагдсан болон хууль бусаар худалдагдсан соёлын өвийг эрэн хайх ажиллагаанд багагүй хүндрэл учруулаад зогсохгүй гадаад орон руу гарах эрсдэлийг дагуулдаг. Энэхүү эрсдлийг бууруулахын тулд соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сантай хил, гааль, цагдаа, тагнуулын байгууллагыг тусгай сүлжээгээр холбож алдагдсан, хууль бусаар худалдагдсан соёлын өвийн талаарх мэдээллээр шуурхай хангах шаардлагатай байна.

Гурав. Хөтөлбөрийн зорилго, зорилт

3.1. Хөтөлбөрийн зорилго

Соёлын өвийн бүртгэл, мэдээллийг дамжуулах, хүлээн авах, баяжуулах үйл ажиллагааг тоон системд оруулан, бүртгэл, мэдээллийн



сангийн тогтолцоог боловсронгуй болгох замаар соёлын өвийн хадгалалт хамгаалалтын аюулгүй байдлыг хангахад хөтөлбөрийн зорилго оршино.

3.2. Хөтөлбөрийн зорилт

3.2.1. соёлын өвийн бүртгэлийн программ хангамжийг шинэчлэн сайжруулах;

3.2.2. соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санг шаардлагатай техник, хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах;

3.2.3. соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд программ хангамж суурилуулах, нэгдсэн сүлжээнд холбох;

3.2.4. соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санчийн чадавхийг дээшлүүлэх;

3.2.5. соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санг хил, гааль, цагдаа, хяналтын байгууллагатай холбох.

Дөрөв. Хэрэгжүүлэх арга зам

4.1. Соёлын биет болон биет бус өвийн бүртгэлийн программ хангамжийг шинэчлэн сайжруулах зорилтын хүрээнд:

4.1.1. музейн үзмэр, эд өлгийн зүйлийн бүртгэлийн RCH (Registration of cultural heritage) программ хангамжийг шинэчлэн сайжруулах;

4.1.2. түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэлийн RICH (Registration of immovable cultural heritage) программ хангамжийг шинэчлэн сайжруулах;

4.1.3. соёлын биет бус өвийн бүртгэлийн ICH (Intangible cultural heritage) программыг шинээр боловсруулах.

4.2. Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санг шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах зорилтын хүрээнд:



4.2.1. тоног төхөөрөмж, техник хэрэгслийг холбогдох хууль тогтоомжийн дагуу худалдан авах;

4.2.2. тоног төхөөрөмж, техник хэрэгслийг орон нутаг тараан байршуулах.

4.3. Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд программ хангамж суурилуулах, нэгдсэн сүлжээнд холбох зорилтын хүрээнд:

4.3.1. соёлын өвийн бүртгэлийн RCH, RICH, ICH программ хангамжийг бүртгэл, мэдээллийн сангийн компьютерт суулгах;

4.3.2. бүртгэл, мэдээллийн санг нэгдсэн сүлжээнд холбох.

4.4. Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санчийн чадавхийг дээшлүүлэх зорилтын хүрээнд:

4.4.1. бүртгэл, мэдээллийн санчийн чадавхийг дээшлүүлэх талаар үе шаттай сургалт зохион байгуулах.

4.5. Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санг хил, гааль, цагдаа, хяналтын байгууллагатай холбох зорилтын хүрээнд:

4.5.1. хил, гааль, цагдаа, хяналтын байгууллагыг шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах;

4.5.2. хил, гааль, цагдаа, хяналтын байгууллагад зориулсан дэд систем боловсруулах;

4.5.3. соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санг хил, гааль, цагдаа, хяналтын байгууллагатай сүлжээгээр холбох;

4.5.4. хил, гааль, цагдаа, хяналтын байгууллагын холбогдох ажилтнуудыг мэргэшүүлж, дадлагажуулах.

Тав. Хөтөлбөрийн хамрах хүрээ

5.1. Байгууллага дахь бүртгэл, мэдээллийн 18 сан

5.2. Сум, дүүргийн бүртгэл, мэдээллийн 340 сан



5.3. Аймаг, нийслэлийн бүртгэл, мэдээллийн 22 сан

5.4. Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан

5.5. Хил, гааль, цагдаа, хяналтын 4 байгууллага

Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага,
зохион байгуулалт

6.1. Хөтөлбөрийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх стратеги төлөвлөлт, удирдлага, зохион байгуулалтаар ханган зохицуулах, хэрэгжилтэд нь хяналт тавих үүргийг соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага гүйцэтгэнэ.

6.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйгээр хангах ажлыг Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан хариуцан зохион байгуулна.

6.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахад бүх шатны Засаг дарга, хил, гааль, цагдаа, хяналтын байгууллагын удирдлагууд дэмжлэг үзүүлнэ.

Долоо. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа

7.1. Хөтөлбөрийг 2015-2016 онд хэрэгжүүлнэ.

Найм. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилт

8.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

8.2. Соёлын өвийн мэдээллийг тоон системд оруулах дотоод сүлжээний хөрөнгийг хөтөлбөр хэрэгжих хугацаанд хөтөлбөрийн зардлаас гаргах ба хөтөлбөр дуусмагц тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга, улсын музейн захирал, бусад байгууллагууд нь тухайн оны төсөвт суулгаж үргэлжлүүлнэ.

Ес. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ:



9.1. Сум, аймаг, нийслэлийн соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан бий болж үйл ажиллагаа нь боловсронгуй болно.

9.2. Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан нь нэгдсэн сүлжээнд холбогдож үндэсний цахим мэдээллийн тогтолцоо бүрдэнэ.

9.3. Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангагдана.

9.4. Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн бүх үйл ажиллагаа тогтмолжиж, бүрдэлт, баяжилтын чанар дээшилнэ.

9.5. Соёлын өвийг эрсдэлээс хамгаалах боломж нэмэгдэнэ.

9.6. Соёлын өвийг хамгаалах үүрэг бүхий төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа сайжирна.

Арав. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

- Бүртгэлийн программ хангамж шинэчлэгдэн сайжирсан байдал;
- Бүртгэлийн программ суурилуулсан бүртгэл, мэдээллийн сангийн тоо;
- Нэгдсэн сүлжээнд холбогдсон бүртгэл, мэдээллийн сангийн тоо;
- Бүртгэл, мэдээллийн сан нь шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангагдсан байдал;
- Бүртгэл, мэдээллийн сангийн чадавх дээшилсэн байдал;
- Төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа сайжирсан байдал;
- Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн үйл ажиллагаа боловсронгуй болж тогтмолжсон байдал.



ҮНДЭСНИЙ СОЁЛЫН ӨВИЙГ БҮРТГЭН БАРИМТЖУУЛАХ
2 ДАХЬ ШАТНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Шаардагдах зардал (төг)	Хариуцах болон хамтран ажиллах байгууллага
1. Соёлын өвийн бүртгэлийн программ хангамжийг шинэчлэн сайжруулах зорилтын хүрээнд:				
	1.1. Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн бүртгэлийн RCH (Registration of cultural heritage) программ хангамжийг шинэчлэн сайжруулах	2015	57.0 сая	ССАЖЯ Соёлын өвийн төв
	1.2. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэлийн RICH (Registration of immovable cultural heritage) программ хангамжийг шинэчлэн сайжруулах	2015	45.0 сая	ССАЖЯ Соёлын өвийн төв
	1.3. Соёлын биет бус өвийн бүртгэлийн ICH (Intangible cultural heritage) программыг шинээр боловсруулах	2015	55.0 сая	ССАЖЯ Соёлын өвийн төв



2. Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санг шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах зорилтын хүрээнд:				
2.1. Тоног төхөөрөмж, техник хэрэгслийг холбогдох хууль тогтоомжийн дагуу худалдан авах	2015	1.303.3 сая	ССАЖЯ Соёлын өвийн төв	
2.2. Тоног төхөөрөмж, техник хэрэгслийг орон нутагт тараан байршуулах	2015	17.8 сая	Соёлын өвийн төв	
3. Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд программ хангамж суурилуулах, нэгдсэн сүлжээнд холбох зорилтын хүрээнд:				
3.1. Соёлын өвийн бүртгэлийн RCH, RICH, ICH программ хангамжийг бүртгэл, мэдээллийн сангийн компьютерт суулгах	2015	3.0 сая	Соёлын өвийн төв	
3.2. Бүртгэл, мэдээллийн санг интернэт сүлжээнд холбох	2015	486.8 сая	ССАЖЯ Соёлын өвийн төв	
4. Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санчийн чадавхийг дээшлүүлэх зорилтын хүрээнд:				
4.1. Бүртгэл, мэдээллийн санчдын чадавхийг дээшлүүлэх зорилгоор үе шаттай сургалт зохион байгуулах	2015-2016	70.7 сая	ССАЖЯ Соёлын өвийн төв	



5. Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санг хил, гааль, цагдаа, хяналтын байгууллагатай холбох зорилтын хүрээнд:

5.1. Хил, гааль, цагдаа, хяналтын байгууллагыг шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах	2016	12.6 сая	ССАЖЯ Соёлын өвийн төв, Хил, гааль, цагдаа, хяналтын байгууллага
5.2. Хил, гааль, цагдаа, хяналтын байгууллагад зориулсан дэд систем боловсруулах	2016	25.0 сая	Соёлын өвийн төв, Хил, гааль, цагдаа, хяналтын байгууллага
Бүгд		2.076 сая	

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2014 оны 7 дугаар
сарын 9-ний өдөр

Дугаар 225

Улаанбаатар
хот

Хөрөнгө гаргах тухай

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 8.3.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Халхын голын 1939 оны байлдааны ялалтын 75 жилийн ойг тохиолдуулан уг байлдаанд оролцсон амьд сэрүүн байгаа ахмад дайчин тус бүрт 2,0 (хоёр) сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж олгосугай.

2. Халхын голын байлдааны түүхэн ач холбогдлыг сурталчилан таниулах ажлыг зохион байгуулж байгаа уран бүтээлчдэд уран бүтээлээ туурвихад нь зориулж 20,0 (хорин) сая төгрөгийн урамшуулал олгосугай.



3. Нэг удаагийн буцалтгүй тусламж олгох болон урамшуулалд шаардагдах нийт 120,0 (нэг зуун хорин) сая төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас гаргахыг Сангийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.АЛТАНХУЯГ

САНГИЙН САЙД

Ч.УЛААН

**БАТЛАН ХАМГААЛАХЫН
САЙД**

Д.БАТ-ЭРДЭНЭ

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medelel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 0.75

Индекс: 14003